




## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

### Нийцлийн аудитын тайлан

#### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



**ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУД  
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.**

Өлгий

# АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b><u>Тайланг бэлтгэсэн:</u></b></p> <p><b>Үндэсний Аудитын газрын харъяа Баян-Өлгий аймгийн аудитын газар</b></p> <p><b>Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор</b><br/>Х.Бекен</p> <p><b>Аудитын менежер</b><br/>Х.Женисбек</p> <p><b>Аудитын баг:</b><br/><b>Ахлах шинжээч</b><br/>С.Салтанат</p> <p><b>Ахлах шинжээч</b><br/>К.Риза</p> <p><b>Шинжээч</b><br/>Х.Еркебулан</p> <p><b>2016 оны 12 дугаар сар</b></p> <p>Аудитын тайланг <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> вэб сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70423073, 70422930, 70422954 дугаарын утсаар харилцана уу</p> <p><b>ХАЯГ:</b><br/>Аймгийн ЗДТГазрын байр, 1 дүгээр давхар 102, 104, 217 тоот өрөө</p> | <p>Товчилсон үгийн тайлбар .....3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-6</p> <p><b>Бүлэг 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа талаар.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан 200 байгууллага шилэн дансны нэгдсэн порталд бүрэн хамрагдсан байна. ....7-9</li> </ul> <p><b>Бүлэг 2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа талаар.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Улсын төсвийн 19 байгууллага, орон нутгийн төсвийн 135 байгууллага шилэн дансны хуулийн зарим заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.....10-15</li> <li>Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ байршуулаагүй байна.....16-16</li> <li>Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 11 байгууллага мэдээллээ шилэн дансны нэгдсэн санд байршуулаагүй байна.....16-17</li> </ul> <p><b>Бүлэг 3. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа талаар.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг улам эрчимжүүлэх шаардлагатай байна. ....18-21</li> </ul> <p><b>Дүгнэлт.....22</b></p> <p><b>Зөвлөмж: .....23</b></p> <p><b>Холбогдох байгууллагын санал: .....24</b></p> <p><b>Саналд өгсөн тайлбар</b><br/>.....</p> |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

## Товчилсон үгийн тайлбар

|                 |                                                     |
|-----------------|-----------------------------------------------------|
| <b>УИХ</b>      | Улсын Их Хурал                                      |
| <b>УБСЕГ</b>    | Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар           |
| <b>АИТХ</b>     | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                |
| <b>ЗДТГ</b>     | Засаг даргын тамгын газар                           |
| <b>СТСХ</b>     | Санхүү төрийн сангийн хэлтэс                        |
| <b>ТЕЗ</b>      | Төсвийн Ерөнхийлөн захирагч                         |
| <b>ТТЗ</b>      | Төсвийн Төвлөрүүлэн захирагч                        |
| <b>ХАА</b>      | Худалдан авах ажиллагаа                             |
| <b>НХҮХ</b>     | Нийгмийн Халамж үйлчилгээний хэлтэс                 |
| <b>ГХБХБГ</b>   | Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар      |
| <b>ЦШСГ</b>     | Цахилгаан шугам сүлжээний газар                     |
| <b>ОНӨААТҮГ</b> | Орон нутгийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар |
| <b>ОНХС</b>     | Орон нутгийн хөгжлийн сан                           |
| <b>БСГ</b>      | Боловсрол соёлын газар                              |
|                 |                                                     |

# Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

## 1. Аудитын зорилт:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрхи зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх талаар;
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх талаар;
- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан байгууллага үүргээ бүрэн хэрэгжүүлж байгаа эсэх талаар;
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх талаар;
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

## 2. Хамарсан хүрээ:

Энэхүү аудитыг Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнууд 2016 оны 10 сарын байдлаар хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг байршуулсан эсэхийг хянан баталгаажуулав.

## 3. Үндсэн мэдээлэл:

Энэхүү аудитаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан эсэх, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх, 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг шалгаж, Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан бүгд 201 байгууллагыг хамруулав.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани 3 төрлийн мэдээлэл тус бүр оруулахаар хуульчилсан байна.

## 4. Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв.

## **5. Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн арга зүйг ашиглахын зэрэгцээ зарим хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа болон судалгаа авах, зөвлөгөө өгөх, дүн шинжилгээ хийх, газар дээр нь явж биет ажиглалт хийх зэрэг арга зүйг ашиглан, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## **6. Аудит хийхэд ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

## **7. Гүйцэтгэх хугацаа:**

Аудитын талбарын ажлыг 2016 оны 10 дугаар сарын 10-наас, тайлагналын үе шатыг 11 дүгээр сарын 14-нээс эхлэн 12 дугаар сарын 7-нд дуусгаж, 12 дугаар сарын 9-ний дотор ҮАГазрын Нийцлийн аудитын газарт файлаар болон цаасаар явуулав.

## **8. Аудитын багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг ахлах шинжээч С.Салтанат ахлаж, ахлах шинжээч К.Риза, шинжээч Х.Еркебулан нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хийж, тайланг бэлтгэв.

## **9. Аудитад шаардагдсан нөөц хөрөнгө, нөөц:**

А. Боловсон хүчин:

- Аймгийн аудитын газраас 3 хүн: 37 өдөр, 96 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц:

- Цалин- 4600.0 мянган төгрөг
- Бичиг хэрэг 20.0 мянган төгрөг
- Томилолтын зардал- 2233.0 мянган төгрөг /Бүх сумдад 4 хүн ажиллахад томилолт 1368.0 мянган төгрөг, шатахууны зардал 765.6 мянган төгрөг/

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, видеое камер, зургийн аппарат болон бусад техник хэрэгсэл.

# Бүлэг 1

*Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан 201 байгууллага шилэн дансны цахим хуудсанд бүрэн орсон байна.*

## Ерөнхий зүйл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн нийцлийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани бүх байгууллагуудын шилэн дансны мэдээллийг хамруулав.

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Шилэн дансны тухай хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар УИХурлаас 2014 оны 7 дугаар сард баталж, 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн байна.

Энэхүү хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2016 оны 29 тогтоолоор “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг шинэчлэн баталж, журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гүйцэтгэгч нарт үүрэг болгожээ.

Аймгийн Засаг даргын 2014 оны “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/415 дугаар захирамжийн дагуу ил тод байдлыг ханган ажилласан ба Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/188 тоот захирамж гарч, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулах ажлыг Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын албанд даалгаж, биелэлтэнд хяналт тавьж ажилласан байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс Шилэн дансны тухай хуулийг сурталчлах, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч нарт албан газрын шилэн дансанд байршуулах мэдээлэл, агуулга, хэлбэр, олон нийтэд мэдээлэх хугацаа, шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсыг хариуцан ажиллуулах талаар дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулжээ.

2014 онд бүх төсвийн байгууллагуудаар явж газар дээр нь төсвийн ил тод байдлын хэрэгжилтэнд хяналт тавьж, мэдээллийн самбар ажиллуулах, вэб сайттай болох даалгавар өгч, Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан бүх төсвийн байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн нэрийн данс, регистрийн нэгдсэн судалгааг гаргаж Сангийн яаманд хүргүүлж, цахим хуудсанд нэвтрэх кодыг олгожээ.

Ингэснээр байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг байршуулж, төсвийн ил тод байдлыг хангах боломж нээгдэж, шилэн дансны нэгдсэн вэб сайтад байршуулсан мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтой болжээ. Шилэн дансны мэдээллийг дутуу оруулсан байгууллага, сумдын нэрсийг тухай бүр орон нутгийн радио, телевизээр мэдээлж ажилласан байна.

Энэхүү аудитаар төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагааг шилэн дансны нэгдсэн мэдээллийн вэб сайт, байгууллагын вэб сайтад тавьсан мэдээллийг шалгаж баталгаажуулсны дээр 12 сумын 55 байгууллага болон аймгийн төвийн бүх байгууллагуудад мэдээллийн самбар ажиллуулж байгаа байдлыг газар дээр нь шалгаж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, засаж залруулах, зөвлөгөө өгөх хэлбэрээр нийцлийн аудитыг хэрэгжүүллээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан ТЕЗ 1, ТТЗахирагч 14, орон нутгийн төсвийн 144, улсын төсвийн 35 байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7, нийтдээ 201 аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хамрагдаж, хуулийн хэрэгжилтийг 2016 оны эхний 10 сарын байдлаар хянан баталгаажуулж, дүнг нэгтгэв.

## **1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа талаар.**

*Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан 201 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн орсон байна.*

### **1.1 Төсвийн ерөнхийлөн захирагч болон Төсвийн төвлөрүүлэн захирагч шилэн дансны мэдээлэлд бүрэн хамрагдаж байгаа талаар:**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагчдын нэр 2015 онд шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд бүртгэгдэж, бие даасан цэс нээгдээгүй байсан ба аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу 2016 оны 1 дүгээр улиралд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд бие даасан цэс нээж, цахим хуудсанд бүрэн бүртгэгдсэн байна.

Зарим мэдээллүүдийг аймгийн ЗДТГазрын шилэн дансан болон [www.bayan-ulqii.gov.mn](http://www.bayan-ulqii.gov.mn) вэб сайтад байршуулсан байна.

### **1.2 Төрийн өмчит буюу улсын төсвийн байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж байгаа талаар:**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын үр дүнгийн Маягт №1-ээс үзэхэд Улсын төсвийн 34 байгууллага бүгд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

### **1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд буюу орон нутгийн төсвийн байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж байгаа талаар:**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын үр дүнгийн маягт №1-ээс үзэхэд орон нутгийн төсвийн 145 байгууллага шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цэс нээж бүртгэгдсэн байна.

Өлгий сумын 15 дугаар цэцэрлэг 2016 оны шилэн дансны нэгдсэн санд цэс нээж, бүртгэгдээгүй, мэдээллээ байршуулаагүй байсан нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “Байгууллага нь шилэн дансны бие даасан цэстэй байна” гэсэн заалтыг зөрчиж байгаа тул аудитын явцад 15 дугаар цэцэрлэгийн холбогдох албан тушаалтнуудад холбогдох дээд байгууллагуудад хүсэлтээ гаргаж, шилэн дансны мэдээллийн санд цэс нээлгэж, бүртгүүлэн мэдээллээ байршуулахыг зөвлөж, цэс нээлгэн холбогдох мэдээллийг бүрэн байршуулсан.

### **2.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж байгаа талаар:**

Нисэх буудал, Радио телевизийн сүлжээний газар, Авто тээврийн төв зэрэг төрийн өмчийн 3 аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд бүртгэгдсэн байна.

### **3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансанд бүрэн хамрагдаж байгаа талаар.**

3.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, аж ахуйн нэгж тус аймагт байхгүй болно.

## Бүлэг 2

*Орон нутгийн байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлж ирсэн байна.*

**2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа талаар.**

**2.1 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг тогтмол мэдээлсэн талаар.**

*Орон нутгийн төсвийн 136, улсын төсвийн 18 байгууллага шилэн дансны хуулийн зарим заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.*

2.1.1 Төсвийн ерөнхийлөн захирагч болон 14 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2016 оны эхний 10 сарын байдлаар шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цэс нээж бүртгэгдэн орж, мэдээллийг байршуулсан боловч зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. Тухайлбал:

- Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннур, Улаанхус, Цэнгэл, Цагааннуур зэрэг 9 сумын ТТЗахирагч тухайн жилийн батлагдсан төсвийн мэдээллийг, Баяннуур, Булган, Улаанхус, Цэнгэл, Цагааннуур сум ОНХСангийн төлөвлөгөө, Алтай, Дэлүүн, Сагсай сумаас бусад 11 сум ХАА-ны төлөвлөгөөг байршуулаагүй хуулийн 6.1.1 дэх заалтыг,
- Алтай, Сагсай сумаас бусад 11 сум төсвийн гүйцэтгэлийн эхний 10 сарын мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй хуулийн 6.1.2 дахь заалтыг,
- ТЕЗ, 14 сумын ТТЗахирагч дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй хуулийн 6.1.3 дахь заалтыг,
- ТЕЗ, 13 сумын ТТЗахирагч санхүүгийн жилийн эцсийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулаагүй хуулийн 6.1.4, 6.1.5 дахь заалтыг,
- Алтай, Алтанцөгц, Бугат сумын ТТЗ-аас бусад ТТЗ-чид төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгааны тайлбарыг, Баяннуур, Бугат, Ногооннур, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Өлгий сум ОНХСангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг, Алтай сумаас бусад 13 сум тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын мэдээллийг байршуулаагүй хуулийн 6.1.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Тус аймгийн [www.bayan-ulgii.gov.mn](http://www.bayan-ulgii.gov.mn) вэб сайтад ОНХСангийн 2016 оны тодотгосон төлөвлөгөө, 2016 оны хуваарь, 2016 оны орон нутгийн төсвийн төлөвлөгөө, 2015 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс санхүүжүүлэх арга хэмжээний жагсаалтын мэдээллийг тус тус байршуулсан байна.

Харин худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг [www.bayan-ulgii.gov.mn](http://www.bayan-ulgii.gov.mn), [www.tender.bo.gov.mn](http://www.tender.bo.gov.mn), [www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn), [www.pmmis.mof.gov.mn](http://www.pmmis.mof.gov.mn) вэб сайтуудад байршуулжээ.

**2.1.2.** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын үр дүнгийн маягт №1-ээс үзэхэд улсын төсвийн 34 байгууллагагаас зарим байгууллага мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. Тухайлбал:

-Боловсрол соёлын газар тухайн жилийн төсвийн төлөвлөгөөг байршуулаагүй хуулийн 6.1.1 дэх заалтыг, Татварын хэлтэс, Дэлүүн Сум дундын эмнэлэг, Боловсрол соёлын газар, НХҮХэлтэс, ГХБХБГазар зэрэг 5 байгууллага төсвийн гүйцэтгэлийг 1-4 сар тогтмол мэдээлээгүй хуулийн 6.1.2 дахь заалтыг,

-21 байгууллага дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй хуулийн 6.1.3 дахь заалтыг,

-Эхний хагас жилийн санхүүгийн тайланг 7 байгууллага, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 18 байгууллага байршуулаагүй хуулийн 6.1.4 дэх заалтыг,

-19 байгууллага 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг, 5 байгууллага санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулаагүй хуулийн 6.1.4, 6.1.5 дахь заалтыг,

-Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг Боловсролын газар байршуулаагүй хуулийн 6.1.6 дахь заалтыг зөрсөн байна.

Улсын төсвийн 34 байгууллагад хавсралт маягт №1-ийн Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд байршуулах 13 мэдээллээс 7 төрлийн мэдээлэлтэй холбоотой ажил гүйлгээ гараагүй учраас ажил гүйлгээ гарсан 6 мэдээллийг үндэслэн дүгнэлт хийлээ.



Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтсийн шилэн дансны мэдээллийн самбар

**2.1.3.** Аудитын үр дүнгийн Маягт №1-ээс үзэхэд орон нутгийн төсвийн 145 байгууллага бүгд шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдэн орж, мэдээллээ байршуулж мэдээлсэн байна.

-Үүнээс Өлгий сумын 15 дугаар цэцэрлэг шилэн дансны нэгдсэн санд цэс нээлгэж, мэдээллээ байршуулаагүй байсныг нийцлийн аудит хийх явцад цэс нээлгэж, мэдээллийг нөхөн байршуулах арга хэмжээ авлаа.

-Орон нутгийн төсвийн 145 байгууллагаас 8 байгууллага буюу Булган сумын ЗДТГазар, Буянт сумын ИТХурал, ЗДТГазар, Цэнгэл сумын 3-р цэцэрлэг, аймгийн төвийн 4 өрхийн эмнэлэг тухайн жилийн төсвийн төлөвлөгөөг байршуулаагүй хуулийн 6.1.1 дэх заалтыг,

-2016 оны эхний 10 сард 7-38 байгууллага төсвийн гүйцэтгэлийг 1-10 сар тогтмол мэдээлээгүй хуулийн 6.1.2 дахь заалтыг,

-96 байгууллага дараа жилийн төсвийн төслийг байршуулаагүй хуулийн 6.1.3 дахь заалтыг,

-Эхний хагас жилийн санхүүгийн тайланг 66 байгууллага, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 91 байгууллага байршуулаагүй хуулийн 6.1.4 дэх заалтыг,

- 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 96 байгууллага, 4 байгууллага санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг байршуулаагүй хуулийн 6.1.5 дахь заалтыг,

-Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг 10 байгууллага байршуулаагүй хуулийн 6.1.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн 145 байгууллагад хавсралт маягт №1-ийн Шилэн дансны нэгдсэн мэдээллийн цахим хуудсанд байршуулах 13 мэдээллээс 7 төрлийн мэдээлэлтэй холбоотой ажил гүйлгээ гараагүй учраас ажил гүйлгээ гарсан 6 мэдээллийг үндэслэн дүгнэлт хийлээ.



Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн мэдээллийн самбар



Булган сумын ЗДТГазрын мэдээллийн самбар

**2.1.4.** ЦШСГазар, “Суат” ХХК, “Жана өлке”, “Хала өркени” ОНӨААТҮГ зэрэг орон нутгийн өмчит 4 байгууллага шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд цэс нээж, бүртгэгдэн орсон боловч холбогдох мэдээллээ хугацаанд нь бүрэн байршуулаагүй байна.Тухайлбал: ЦШСГазар нь хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудыг, “Суат” ХХК, Жана өлке ОНӨААТҮГ, “Хала өркени” ОНӨААТҮГ нь хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**2.1.5.** Нисэх буудал, Радио телевизийн сүлжээний газар, Авто тээврийн төв зэрэг төрийн өмчит 3 аж ахуйн нэгж шилэн дансны мэдээллийн санд зарим мэдээллийг дутуу байршуулсан байна.

- Радио телевиз сүлжээний газар маягт № 1-д заасан байршуулбал зохих 4 мэдээллээ байршуулаагүй 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5 дахь заалтыг, Нисэх буудал 1 мэдээллээ байршуулаагүй 6.1.3 дахь заалтыг, Авто тээврийн төв нь 2 мэдээллээ бүрэн байршуулаагүй 6.1.2, 6.1.3 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

**2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг тогтмол мэдээлсэн талаар.**

**2.2.1** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын үр дүнгийн маягт №2-оос үзэхэд Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон 14 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нар 2016 оны эхний 10 сарын байдлаар холбогдох мэдээллийг байршуулж ирсэн боловч дараах зөрчил илэрчээ.

-Аймгийн Засаг дарга болон 11 сумын ТТЗахирагч тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг байршуулаагүй хуулийн 6.4.1 дэх заалтыг, ТЕЗ төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй хуулийн 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

**2.2.2** Аудитын үр дүнгийн маягт №2-оос үзэхэд Улсын төсвийн 34 байгууллагаас 31 байгууллага тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон мэдээлсэн ба 3 байгууллагын төсөвт өөрчлөлт ороогүй байна. Энэхүү улсын төсвийн 34 байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй байна.

-Тендер худалдан авалттай холбоотой мэдээллийг 2 байгууллага байршуулсан ба 32 байгууллагад үйл ажиллагаа гараагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой мэдээллийг 6 байгууллага мэдээлсэн, 28 байгууллагад үйл ажиллагаа гараагүй байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 34 байгууллагад энэхүү мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа гараагүй байна.

-Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээний зарлага 13 байгууллагад гарч 3693.2 сая төгрөгийн мэдээллийг мэдээллийн санд байршуулсан бол 21 байгууллагад энэхүү ажил гүйлгээ гараагүй байна.

-Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнтэй холбоотой үйл ажиллагаа бүх байгууллагад гараагүй байсан ба байгууллагын батлагдсан орон тооны өөрчлөлт 24 байгууллагад гарсныг

мэдээллийн санд байршуулсан, 1 байгууллага байршуулаагүй, 9 байгууллагад орон тооны ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

-Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэлийн талаарх шийдвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ хамааралгүй байсан ба концессийн болон өр, авлага үүссэн шийдвэрийн талаарх мэдээлэл бүх байгууллагад гараагүй байна.

-Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх мэдээллийг 4 байгууллага мэдээллийн санд байршуулж, 30 байгууллагад энэхүү үйл ажиллагаа гараагүй байна.

-Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл бүх байгууллагад гараагүй байна.

**2.2.2.** Аудитын үр дүнгийн маягт №2-оос үзэхэд орон нутгийн төсвийн 145 байгууллагаас 96 байгууллагын тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон мэдээлж, 7 байгууллагын төсөвт ямар нэгэн өөрчлөлт ороогүй ба 42 байгууллага мэдээллээ байршуулаагүй хуулийн 6.4.1 дэх заалтыг зөрчсөн байна. 145 байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт ороогүй байна.

-Энэхүү байгууллагуудад тендер худалдан авалттай холбоотой мэдээлэл гараагүй байсан бол, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 208.7 сая төгрөгийн мэдээллийг 8 байгууллага байршуулж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 145 байгууллагад буюу энэхүү мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа гараагүй байна.

-Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээний зарлага 33 байгууллагад гарч 2108.0 сая төгрөгийн мэдээллийг мэдээллийн санд байршуулсан бол 83 байгууллагад энэхүү ажил гүйлгээ гараагүй ба 29 байгууллага мэдээллээ байршуулаагүй хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

-Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагаа бүх байгууллагад гараагүй байсан ба байгууллагын батлагдсан орон тооны өөрчлөлт 118 байгууллагад гарсныг мэдээллийн санд байршуулсан бол 8 байгууллагын орон тоонд өөрчлөлт ороогүй, 19 байгууллага мэдээллээ байршуулаагүй хуулийн 6.4.7 дахь заалтыг зөрчсөн байна.

-Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгслийн талаарх шийдвэр, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ хамааралгүй байсан ба концессийн талаарх шийдвэрийн үйл ажиллагаа, өр, авлага үүссэн шийдвэрийн талаарх мэдээлэл 145 байгууллагад ямар нэгэн үйл ажиллагаа гараагүй байна.

-Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн талаарх мэдээллийг 9 байгууллага мэдээллийн санд байршуулж, 94 байгууллагад үйл ажиллагаа гараагүй ба 42 байгууллага мэдээллийн санд мэдээллээ байршуулаагүй хуулийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.

-Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл гараагүй байна.

**2.2.3.** Маягт №2-оос үзэхэд ЦШСГазар, “Суат” ХХК, “Жана өлке”, “Хала-Өркени” ОНӨААТҮГ зэрэг орон нутгийн өмчит байгууллага шилэн дансны 1-10 сард мэдээлэх ёстой мэдээллийг бүрэн байршуулаагүй ЦШСГазар нь хуулийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7, 6.4.8 дахь заалтуудыг, “Суат” ХХК нь хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудыг, “Жана өлке” ОНӨААТҮГ нь хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг, “Хала-Өркени” ОНӨААТҮГ нь хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**2.2.4.** Аудитын маягт №2-оос үзэхэд Радио телевизийн сүлжээний газарт үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүй ба Нисэх буудал, Авто тээврийн төв нь төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг дээрхи 3 байгууллага байршуулж, бусад ажил үйлчилгээ гараагүй байна.

**2.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн талаар.**

**2.3.1.** Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, аж ахуйн нэгж тус аймагт байхгүй байна.

**2.4. Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан албан тушаалтнууд мэдээллийг хуулийн дагуу иргэн, олон нийтэд хүргэх үүргээ биелүүлсэн талаар.**

**2.4.1.** Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан албан тушаалтнууд Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 тоот тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллээ хугацаанд нь бүрэн мэдээлж, иргэн, олон нийтэд хүргэх үүргээ биелүүлсэн байх ёстой.

Энэхүү үүргээ хэрхэн биелүүлснийг судалгаанаас үзэхэд шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т заасан 154 байгууллагын албан тушаалтнууд мэдээллийг хуулийн дагуу иргэн, олон нийтэд хүргэх үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нарт шилэн дансны нэгдсэн санд байршуулбал зохих мэдээллийг дутуу байршуулсан, огт байршуулаагүй төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч нарт зөрчлийн шинж байдлыг харгалзан ажлын хариуцлага тооцож, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дутуу байршуулсан буюу огт байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

**2.5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл байршуулсан талаар.**

*Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээлэл байршуулаагүй байна.*

2.5.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 19 дүгээр хавсралт маягтын дагуу аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн гэсэн цэсэнд байршуулж мэдээлж байх ёстой атал 65 аж ахуйн нэгж, байгууллага 6460.4 сая төгрөгийн санхүүжилтийг мэдээлээгүй хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтыг зөрчсөн байна.

2.5.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын явцад Сангийн яамны “mof.gov.mn” сайтад сумдын ОНХС-ийн мэдээлэл байршуулсан байдлыг шалгаж үзэхэд тус сайтад 13 сум, 1 тосгоны ОНХС-ийн цэс нээгдсэн байна.

Уг сайтад ОНХС-ийн сар бүрийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнийн дүнгээр болон хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр оруулах ёстой боловч Сагсай, Бугат сумууд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр байршуулах мэдээллийг огт байршуулаагүй, бүх сум ОНХС-ийн сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үнийн дүнгээр нь мэдээлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөрийн нэрээр нь оруулах мэдээлэлд эрх зүй, тендерийн талаар, төлбөр тооцоо, зураг төсөв, гүйцэтгэл, хүлээж авсан акт, санал, гомдол зэрэг мэдээллүүдийг дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх ёстой юм.

Сумдын мэдээлэл тавьсан байдлаас үзэхэд 2,3 дахь буюу тендер болон төлбөртэй холбоотой мэдээллүүдийг Сагсай, Бугатаас бусад сум байршуулж ирсэн ба бүх сум 1, 4, 5 дахь мэдээлэлийн хэсэгт огт мэдээлэл байршуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр шалгарсан ААН-ийн нэр, гэрээний хугацаа, олгосон санхүүжилтийн хэмжээний талаар мэдээлэл байршуулсан боловч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дугаар, ажлын зураг төсөв, гүйцэтгэл, хэрэгжсэн арга хэмжээг хүлээж авсан акт, хэрэгжилттэй холбоотой гарсан санал гомдол зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй байна.

**2.6. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгчийн мэдээллийг байршуулсан талаар.**

*Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 11 байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ байршуулаагүй байна.*

2.6.1. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага санхүүжилтийн талаарх улирал бүрийн мэдээллийг дараа сарын 15-ны дотор Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 19 дүгээр хавсралт маягтын дагуу аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн гэсэн цэсэнд байршуулж мэдээлж байх ёстой атал мэдээлээгүй хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэхь заалтыг зөрчсөн байна.

2.6.2. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн Ерөнхий боловсролын 6 сургууль, 6 хүүхдийн цэцэрлэг нийтдээ 12 байгууллага тусгай зөвшөөрлийн дагуу боловсролын үйл ажиллагаа явуулж, оны эхнээс эдгээр байгууллагуудад нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтээр 1409.6 сая төгрөгийн санхүүжилт олгогджээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын явцад шилэн дансны нэгдсэн санд хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүдийн мэдээлэл тавьсан эсэхийг шалгаж үзэхэд “shilen dans.gov.mn” нэгдсэн санд “Руханият” ахлах сургууль сар бүрийн мэдээллээ бүрэн байршуулсан ба бусад сургууль, цэцэрлэгүүд байршуулбал зохих мэдээллээ огт байршуулаагүй байна.

Маягт №5 буюу хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгүүдэд олгосон санхүүжилт болон бусад мэдээллүүдийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, БСГазрын холбогдох албан тушаалтнуудаас авсан мэдээллийн дагуу гаргалаа.

Маягт №4, 5-аар байршуулах ёстой мэдээллүүдээ бүрэн нөхөж байршуулах талаар холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өгсөн болно.

## Бүлэг 3

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.*

**4. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа талаар.**

**4.1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа талаар.**

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлэх шаардлагатай байна.*

4.1.1. Шилэн дансны тухай хуулийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу Аймгийн ИТХурлаас 2015 оны 10 дугаар сард ажлын хэсэг томилж, төсвийн бүх байгууллагад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг тооцож ажилласан байна.

Аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2015 оны 10 дугаар сард эхний 9 сарын байдлаар, 12 дугаар сард эхний 11 сарын байдлаар, 2016 оны 4 дүгээр сард эхний 3 сарын байдлаар тус тус шалгаж дүгнэлт гаргаж, шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээллийг нөхөж байршуулахыг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад албан шаардлага, зөвлөмж өгч, шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн орон нутгийн төсвийн 108, улсын төсвийн 9 байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах санал хүргүүлж биелэлтэнд хяналт тавьж ажиллав.

4.1.2. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ”, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд Аймгийн Засаг даргын 2015 оны “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” А/188 тоот захирамж гарч, ажлын хэсэг байгуулжээ.

Захирамжаар Санхүүгийн хяналт, аудитын албанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангаж

ажиллаагүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох саналыг тухай бүрт боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, сумдын Засаг дарга нарт танилцуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нэгдсэн шалгалтыг хагас, бүтэн жилээр тогтмол зохион байгуулж, тайлагнах, шаардлагатай нөхцөлд хэсэгчилсэн хяналт, шалгалтыг зохион байгуулах талаар үүрэг өгөгдсөн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь дээрхи захирамжийн дагуу сум, байгууллагуудыг дотоод хяналтын ажилтнуудад хуваарилж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн мэдээг нэгтгэн гаргаж Сангийн яаманд явуулж, хоёр удаа хяналт, шалгалт хийж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, тодорхой шийдвэр гаргуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 8.1-д “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана”, 8.2-т “Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ”, 8.5-т “Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж заасны дагуу Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж байх үүрэгтэй байгууллага юм.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан байна. Үүнд:

2015 оны 12 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн 36 байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд оруулж, Засаг даргын 2015 оны А/559 тоот захирамжаар дээрхи байгууллагуудын албан тушаалтануудад хариуцлага тооцож сахилгын шийтгэл ногдуулж арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитын газраас 2015 оны 12 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудитын тайлан, аймгийн Засаг даргад хүргүүлсэн 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 06/44 тоот албан шаардлага, 2016 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 тоот албан бичгийн дагуу Засаг даргын 2016 оны А/52 тоот захирамж гаргуулж Шилэн дансны тухай хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн 108 байгууллагын 183 албан тушаалтанд “сануулах” арга хэмжээ авч, захирамжийн биелэлтийг тус газарт ирүүлсэн.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016 оны 1 дүгээр сард Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтарч төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, нягтлан бодогч нарт “Шилэн дансны мэдээллийн нэгдсэн сан” сэдэвт семинар зохион байгуулж, нэгдсэн системд ороогүй байгууллагуудыг мэдээллийн баазад шинээр бүртгүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Мөн түүнчлэн 2016 оны 1 дүгээр сард тус албанаас шилэн дансны хэрэгжилтэнд хяналт тавих 1 дүгээр улирлын ажлын төлөвлөгөө боловсруулан, 1, 2 дугаар сард шилэн дансны мэдээллийг шалгаж, мэдээлэлийг дутуу оруулсан 112 байгууллагын жагсаалтыг гаргаж, байгууллагуудын шилэн данс хариуцсан албан тушаалтнуудад зөвлөгөө өгч ажиллажээ.

Үндсэний аудитын газрын 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2/149 тоот албан бичгийн дагуу улсын төсвийн 34, орон нутгийн төсвийн 154 байгууллага, төрийн өмчит 3, орон нутгийн өмчийн 5 аж ахуйн нэгж, 53 сангийн дэлгэрэнгүй судалгааг батлагдсан маягтын дагуу гаргаж, байгууллагын гэрчилгээний хуулбарын хамт Аудитын газарт ирүүлж хянуулсан байна.

Сангийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 12-1/2061 тоот албан бичгийн хүрээнд Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын Шилэн дансны 1 дүгээр улирлын тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, төрийн өмчит хуулийн этгээдийн 34, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 145 байгууллага, ОНӨААТҮГ, ТӨҮГ-ын 7 байгууллагын мэдээллийг бүрэн оруулж Сангийн яаманд хугацаанд нь явуулжээ.

Харин Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу шилэн дансны 2 улирлын тайланг цаасаар хүлээж авахгүй байх, нэгдсэн цахим хуудаснаас татан авахаар болсонтой холбогдуулан бүх төсвийн байгууллагууд өөрсдийн “Байгууллагын админ” эрхээр шилэн дансны системд нэвтрэн орж, өөрийн шилэн дансны 2 дугаар улирлын тайланг цахим системээр дамжуулан дээд байгууллагад илгээх талаар зааварчилгаа, мэдээллийг бүх харъяа агентлаг, байгууллагуудад хүргүүлж ажиллах тухай мэдээлэл өгч ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн аудитын дүнгээс үзэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалтыг тогтмол хугацаанд хэрэгжүүлж, шалгалтын дүнгээр тодорхой арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч аж ахуйн нэгж, байгууллагууд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар санаачлага гаргаж ажиллаагүй, ихэнхи байгууллагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг дахин давтан гаргасан байна.

Мөн түүнчилэн төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмын заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх зарчмыг баримталж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаж чадаагүй байна.

#### **4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар.**

Аймгийн Аудитын газраас 2015 оны 11,12 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийгдсэн аудитын дүнгээр аймгийн Засаг даргад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн 108 төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлж, 3 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба энэхүү албан шаардлагын заалтын дагуу орон нутгийн төсвийн байгууллагуудын нийтдээ 183 албан тушаалтанд хариуцлага тооцож, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн.

Мөн Шилэн дансны тухай хууль, тогтоомжийг хангалтгүй хэрэгжүүлсэн улсын төсвийн 9 байгууллагын дарга, захирал, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар албан шаардлага хүргүүлснээр 12 албан тушаалтанд хариуцлага тооцсон байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2016 оны эхний 3 сарын байдалд хийсэн нийцлийн аудитын үр дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгах, засаж залруулах, шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд байршуулаагүй 130 байгууллагын мэдээллийг нөхөн байршуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлж, биелэлтийг тооцож ажилласан байна.

Нийцлийн аудитын үр дүнгээр шилэн дансны нэгдсэн санд байршуулбал зохих мэдээллээ дутуу байршуулсан буюу огт байршуулаагүй 149 төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын дарга, захирал, эрхлэгч, нягтлан бодогч нарт 3 удаа хийгдсэн нийцлийн аудитаар нэг удаа хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн, 2-3 удаа хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж, зөрчлийг давтан гаргасан байдлыг нь харгалзан үзэж ажлын хариуцлага тооцох, шилэн дансны нэгдсэн санд байршуулбал зохих мэдээллээ дутуу байршуулсан буюу огт байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах арга хэмжээг авч, албан шаардлагын хэрэгжилтийг нь Аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 01-ний дотор хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга нарт даалгав.

Энэхүү албан шаардлагын мөрөөр одоогийн байдлаар 42 байгууллагын 42 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 68 байгууллага шилэн дансны нэгдсэн санд дутуу байршуулсан буюу огт байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулах арга хэмжээг авч хариу өгсөн байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1,3.1.2-т заасан 201 байгууллага шилэн дансны нэгдсэн порталд бүрэн хамрагдсан байна.
2. Сумдын 14 Төсвийн төвлөрүүлэн захирагч, орон нутгийн төсвийн 121, улсын төсвийн 19 байгууллага шилэн дансны нэгдсэн санд байршуулбал зохих мэдээллээ дутуу байршуулсан буюу огт байршуулаагүй байна.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ байршуулаагүй байна.
4. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 11 байгууллага мэдээллээ шилэн дансны нэгдсэн санд байршуулаагүй байна.
5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг зохих түвшинд хэрэгжүүлж байгаа боловч үр дүнд хүрээгүй байна.

# Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурьдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

**Аймгийн засаг дарга А.Гылымхан, Санхүүгийн хяналт, дотоод албаны дарга Х.Хайратхан нарт:**

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөн байршуулах арга хэмжээг авах.

2. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага мэдээллээ шилэн дансны нэгдсэн санд мэдээллээ нөхөн байршуулах арга хэмжээг авах.

3. Шилэн дансны тухай хууль, эрх зүйн актуудыг сурталчилах ажлыг эрчимжүүлж, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, байгууллагын нягтлан бодогч нарыг нэгдсэн арга зүйгээр хангаж, аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулж ажиллах.

4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

## Холбогдох байгууллагын санал

(.....Байгууллагын нэрийг оруулах.....) ирүүлсэн санал:

  
**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
АУДИТЫН АЛБА**  
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-3401

2016. 12. 07 № 101  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2016 оны эхний 10 сарын байдалд хийгдсэн нийцлийн аудитын тайлантай танилцаж үзлээ.

Уг тайлан нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хүрээнд үнэн зөв, бүрэн хийгдсэн байна. Харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан танай хамт олонд талархал илэрхийлье.

ДАРГА  ХАЙРАТХАН

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2016 оны эхний 10 сарын байдалд хийгдсэн нийцлийн аудитын тайлантай танилцаж үзлээ.

Уг тайлан нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хүрээнд үнэн зөв, бүрэн хийгдсэн байна. Харилцан мэдээлэл солилцож, хамтран ажилласан танай хамт олонд талархал илэрхийлье.

**ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.БЕКЕН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.ЖЕНИСБЕК

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

|               |             |
|---------------|-------------|
| АХЛАХ ШИНЖЭЭЧ | С.САЛТАНАТ  |
| АХЛАХ ШИНЖЭЭЧ | К.РИЗА      |
| ШИНЖЭЭЧ       | Х.ЕРКЕБУЛАН |